



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/193

Мандалговь

“Дэвжих-Эрдэнэ” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн А/152 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймгийн төвийн авто замын засвар, хурд сааруулагч”-ийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Дэвжих-Эрдэнэ” ХХК-тай 133,033,300 (нэг зуун гучин гурван сая гучин гурван мянга гурван зуу) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Аймгийн төвийн авто замын засвар, хурд сааруулагч” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Дэвжих-Эрдэнэ” ХХК-ийн захирал (Д.Баянбаатар)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хот тохижуулах газрын дарга (А.Анхбаяр), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН



Хуульч
МОНГОЛ
2020

482069768